

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/231/НА-СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2024 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 92113932 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Л.Мандахнаран Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,696.7	181,376.3	119,479.6
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	49,709.1	54,199.8	4,490.7
Үндсэн хөрөнгө	1,428,854.9	1,385,887.0	-42,791.9
Нийт хөрөнгө	1,486,260.7	1,567,439.1	81,178.4
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,486,260.7	1,567,439.1	81,178.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,486,260.7	1,567,439.1	81,178.4

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 зөрчилтэй асуудал илрүүлж зөрчлийг арилгах 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Газар эзэмших эрхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус хүүхдийн цэцэрлэг нь Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 дугаар багийн нутагт нийт 6425 м.кв газар дээр үйл ажиллагаа явуулж байгаа боловч тухай газрыг эзэмших эрхийн гэрчилгээгүй байна. Одоогоор тус газрын эзэмших эрхийн гэрчилгээ нь Мөрөн сумын ЗДТГ-ын нэр дээр байна. Энэ нь Газрын тухай хуулийн 27.1 дэх “Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ” заалттай нийцэхгүй ба “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын асуудал хариуцсан эрх бүхий байгууллагад хандаж үйл ажиллагаа явуулж буй газрын эзэмших эрхийн гэрчилгээг өөрийн байгууллагын нэр дээр шилжүүлэх арга хэмжээг авч ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Газар эзэмших эрхтэй холбоотой асуудал	1	0					1	0
Дүн	1	0					1	0



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 01/24
танай _____-ны № _____-г

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН
СУМЫН ХҮҮХДИЙН 14 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
П.БАЙГАЛМАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгийн дүн өмнөх оноос 119,479.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллага нь авлагагүй, өглөггүй, хүлээгдэж буй гүйцэтгэл байхгүй, төсөв тодотгох шаардлагагүй байхад тайлант оны төгсгөлд Боловсролын ерөнхий газраас ямар нэгэн шийдвэргүйгээр төрийн сангийн зарлагын гүйлгээ хаах үеэр буюу 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 13,523.1 мянган төгрөгийн санхүүжилт нэмж олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус хүүхдийн цэцэрлэг нь Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 дугаар багийн нутагт нийт 6425 м.кв газар дээр үйл ажиллагаа явуулж байгаа боловч тухай газрыг эзэмших эрхийн гэрчилгээгүй байна. Одоогоор тус газрыг эзэмших эрх нь Мөрөн сумын Засаг даргын Тамгын газарт байна.

6724040121

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЗБААТАР

